

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2026 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ТАЙЛАН

2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Улсын бүртгэлийн ерөнхий газар нь аж ахуйн нэгж, иргэдээс өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бичгээр, амаар, цахим сүлжээ, иргэд олон нийттэй харилцах Улсын бүртгэлийн мэдээлэл лавлагааны 1800-1890 утас болон Засгийн газрын 11-11 төвийн нээлттэй утсаар хүлээн авч холбогдох албан тушаалтанд танилцуулж бүртгэл хяналтын шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2026 оны 1-р улирлын байдлаар иргэд, аж ахуй нэгж байгууллагаас нийт 365 өргөдөл гомдол ирүүлсэн байна. Үүнд:

- Хүсэлт – 279 (76 %)
- Гомдол – 83 (22.7 %)
- Мэдэгдэл – 1 (0.3 %)
- Санал - 2 (0.6 %)

БҮТЦИЙН НЭГЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Иргэний улсын бүртгэлийн газар – 106 (29.1 %);
- Хяналт шалгалтын газар – 97 (26.6 %);
- Тамгын газар - 76 (20.9 %)
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар - 40 (11 %)
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар - 28 (7.7 %)
- Улсын бүртгэлийн нэгдсэн архив - 18 (4.7 %)

ХҮЛЭЭН АВСАН СУВАГ

- Биечлэн - 166 (73.1%)
- Албан бичгээр - 71 (10.2%)
- 11-11 төвөөр - 45 (7.8%)
- Цахимаар - 59 (6.3%)
- Утсаар - 24 (2.6%)

Шийдвэрлэсэн өргөдөл, хүсэлтийг агуулгаар ангилж харуулбал;

Д/д	Агуулга	Шийдвэрлэсэн тоо
1	Иргэний бүртгэл / төрөлт, гэрлэлт, нас баралт, регистр /	78
2	Бичиг баримт / иргэний үнэмлэх, гадаад паспорт /	62
3	Тоон гарын үсэг	28
4	Лавлагаа, тодорхойлолт	51
5	Газрын асуудал	14
6	Системийн алдаа /ажиллахгүй, гацах /	18
7	Хаяг, шилжилт, оршин суугаа бүртгэл	12
8	Хүүхэд, гэр бүлийн асуудал	11
9	Тэтгэвэр, халамж	5
10	Татвар, санхүү	3
	Нийт	282

Улсын бүртгэлийн ерөнхий газарт ирүүлсэн нийт 282 өргөдөл, хүсэлтээс 268-г шийдвэрлэсэн байх ба 96 хувьтай байна. Хуулийн дагуу шийдвэрлэх боломжгүй 1, харьяаллын дагуу шийдэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн 2, хуулийн хугацаа болоогүй 11 хүсэлт байна. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл байхгүй.

Шийдвэрлэсэн гомдлыг агуулгаар ангилж харуулбал;

Д/д	Агуулга	Шийдвэрлэсэн тоо
1	Иргэний бүртгэлтэй холбоотой /иргэний үнэмлэх, шилжилт хөдөлгөөн, бүртгэлийн алдаа/	30
2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой /өмчлөл, гэрчилгээ, үл хөдлөх шилжүүлэх/	10
3	Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой /компанийн бүртгэл, өөрчлөлт, лавлагаа/	5
4	Албан хаагчийн ёс зүй, харилцаатай холбоотой / хандлага, ёс зүйгүй байдал, мэдээлэл буруу өгөх	18
5	Хүний нөөц орон тооны талаар / ачаалал их, ажилтан хүрэлцэхгүй, зохион байгуулалт/	12
6	Системийн алдаа /ажиллахгүй, гацах /	8
	Нийт	83

Улсын бүртгэлийн ерөнхий газарт ирүүлсэн нийт 83 гомдолоос 71-г шийдвэрлэсэн байх ба 92 хувьтай байна. Харьяаллын дагуу шийдэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн 4, хуулийн хугацаа болоогүй 7, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн 1 гомдол байна. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн гомдол байхгүй.